

Дундговь аймгийн Засаг даргын Эдийн засаг, хөгжлийн сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2022.12.13


Аймгийн Засаг даргын Эдийн засаг, хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын Эдийн засаг, хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 9 үүргийг хүлээж, эхний хагас жилийн байдлаар 90.3 хувьтай, жилийн эцсийн байдлаар 93.3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Нийт 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 5 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 70 хувьтай байна.




ХОЁР.ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хот хөдөөгийн сэргэлтийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 12 дугаар хуралдаанаар “Нээлттэй аймаг” хөтөлбөрийг боловсруулан батлуулсан. Мөн тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг аймгийн орон нутгийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр 2023 оны төсөвт 300.0 сая төгрөг тусгууллаа.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр 7 арга хэмжээ, 1 зорилт 3 арга хэмжээ, нийт 1 зорилт 10 арга хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.

Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан 6 салбарын сэргэлт тэр дундаа аж үйлдвэржилт, хот хөдөөгийн, ногоон хөгжлийн, төрийн бүтээмжийн сэргэлтийг орон нутагт дэмжин ажиллаж байна. Уг ажлын хүрээнд “Дундговвио ногооруулъя” дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж нийт 122884 мод тарьж усалгаа арчилгаа хийж аймгийн ногоон байгууламжийн нэмэгдүүлээд байна.

Аймгийн хэмжээнд тарьсан модны тоо



“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 онд орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчин бэлтгэх, зорилтын хүрээнд орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн, соёлын салбарт шаардлагатай төгсөх курсын 22 оюутантай гэрээ байгуулан 57.3 тэтгэлэгт хамрууллаа.



Төрийн албан хаагчийн ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд орон нутагт ажиллаж амьдарч байгаа албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж 4 сумын 4 төрийн албан хаагчид монгол гэрийн дэмжлэг -12,0 сая төгрөг, Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа 8 төрийн албан хаагчид байр орон сууцны дэмжлэг - 67,0 сая төгрөг, Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахаар 7 сумын ЗДТГ-т нэн шаардлагатай тоног төхөөрөмж -20,0 сая төгрөг, Эрүүл мэндийн дэмжлэг тусламж нэн шаардлагатай байгаа 4 төрийн албан хаагчид -25,0 сая төгрөг, Удирдлагын академийн мэргэшүүлэх багш сургалтад 7 төрийн албан хаагчийг хамруулж 11,3 сая төгрөг, Глобаль удирдагч их сургуулийн магистрын ангид суралцаж байгаа 160 төрийн албан хаагчид 66.0 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж нийт нийт 190 төрийн албан хаагчид 201,1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.



Аймгийн дүнгээр 52.1 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж явцын мэдээллийг шилэн данс, орон нутгийн хөгжлийн сан болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем, аймгийн веб сайтад тухай бүр байршуулаад байна. Мөн тухайн төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглалтад оруулсан тухай бүр болон хагас жил тутамд явцын тайланг иргэдэд цахимаар хүргэж байна.



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар
 1 September

ГЭР ХОРООЛЛУУДАД ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАА
 2022 оны аймгийн ОНХС-ийн 300 сая төгрөгийн санхүүжилтээр Айраг, Мандал, Боржигон багуудын гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, ЗТЗ сагсны талбайг шинээр байгуулаа. Гүйцэтгэгчээр Мандал шилтгэн компани ажиллаж байна. Аймгийн удирдлагууд тус бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих, цаашид тоглоомын талбайн тоо, төрлийг нэмэгдүүлэх, эвдэж сүйтгэхгүй байх тал дээр хэрхэн арга хэмжээ авах талаар санал солилцлоо. Тус тоглоомын талбай нь хүүхэд багачуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээн байгуулалт болсон бөгөөд цаашид эвдэж сүйтгэхгүй байх, хайрлаж, хамгаалахыг хүүхэд багачууд, эцэг эх, асран хамгаалагчид, ойр орчмын оршин суугчдад уриалж байна.



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар
 30 May

ДУНДГОВЬ АЙМАГТ "УСАН БАССЕЙН БҮХИЙ СПОРТ ЦОГЦОЛБОР"-ЫН БАРИЛГА БАРИГДАНА
 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 13.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Усан бассейны бүхий спорт цогцолбор"-ын бүтээн байгуулалт Мандалговь хотод хийгдэж бөгөөд энэ онд 1.6 тэрбум төгрөгийн ажил хийгдэхээр тусгагдаж, тус бүтээн байгуулалтын суурийн газар шорооны ажил хийгдэж байна. Захиалагч: Биеийн тамир, спортын улсын хороо Гүйцэтгэгч: "Жи Жи Ай" ХХК Зураг төсөл зохиогч байгууллага: "Эзд проект" ажиллах юм.



ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хугацаанд боловсруулан батлуулах ажил хуулийн хугацаанд хийгдээгүй 2022 оны 12 сарын 5-ны хурлаар батлуулсан.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Эдийн засаг, хөгжлийн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг **93.3** хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3б хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшинг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 18.5 –д “Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна” гэж заасны дагуу хугацаанд боловсруулж батлуулж байх

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг